# ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 31 -ны өдөр Дугаар А/06 Эрдэнэт

"Шинэ коронавирус /covid-2019/ халдвар"ын
болзошгүй үеийн бэлэн байдал,
тандалт, хариу арга хэмжээг
хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Шадар сайдын 2017 оны 08 дугаар тушаалын 5.6.1, 5.6.2, Эрүүл мэндийн сайдын 2017 оны "Шуурхай мэдээлэл, тохиолдлын удирдлагын тогтолцооны талаар авах арга хэмжээний тухай" 2.4, 2.5, ЭМС-ын 2020 оны 19 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн Шинэ коронавирус /2019-covid19/ халдвар-ын үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж хэрэгжүүлэх, үнэн зөв мэдээллээр хангах, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Шинэ коронавирус /covid-2019/ халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангаан, болзошгүй эрсдэлийн үед ажиллах төлөвлөлт, тандалт, хариу арга хэмжээний багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, багийн тохиолдол дэгдэлтийн үед авах арга хэмжээг хоёрдугаар, бэлэн байдал, нөөц хангалт эмнэл зүйн багийн ажиллах журмыг гуравдугаар, мэдээлэл, харилцаа холбоо, сургалт, сурталчилгааны багийн ажиллах журмыг дөрөвдүгээр, үйл явдлыг мэдээлж бүртгэх хүснэгтийг тавдугаар, хариу арга хэмжээг зохион байгуулах хугацаа, хэрэгжүүлэх арга хэмжээний хуудсыг зургаадугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Шинэ коронавирус /covid-2019/ халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах чиглэлээр зохион байгуулалтын шуурхай арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагуудын Захирал, Дарга нарт үүрэг болгосугай.

3. Шинэ коронавирус /covid-2019/ халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангаан хариу арга хэмжээ авч ажилласан албан хаагчдад холбогдох эрхзүйн хүрээнд нэмэгдэл хөлсийг тооцож олгохыг эрүүл мэндийн байгууллагуудын Захирал, Дарга, Эрхлэгч нарт даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд явцын хяналт үнэлгээ хийж, танилцуулж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, Эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүй, эргэн мэдээллээр хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтэс /Б.Уртнасан/-д даалгасугай.

ДАРГА Ц.МӨНХЦЭЦЭГ

My doc. EMG-iin dargiin tushaal

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 01 сарын 21 -ны А/05
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

**1.Төлөвлөлт, тандалт, хариу арга хэмжээний баг**

Ахлагч: Эрүүл мэндийн газрын дарга

Гишүүд:

- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн дарга
- Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга
- Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга
- Халдварт өвчин, тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн
- БОЭТ-ийн Захирал
- БОЭТ-ийн тархвар судлаач эмч
- БОЭТ-ийн Халдвартын тасгийн эрхлэгч
- Өрхийн Анагаах ухааны холбооны Тэргүүн
- Хувийн хэвшлийн Чандмань эрдэнэ холбооны тэргүүн
- Эм холбооны тэргүүн
- Медипас төв эмнэлгийн Эмчилгээ эрхэлсэн орлогч захирал
- Медипас төв эмнэлгийн тархвар судлаач эмч
- Эрдэнэт сувиллын цогцолборын Ерөнхий эмч
- Эрдэнэт сувиллын цогцолборын тархвар судлаач эмч

**2. Бэлэн байдал, нөөц хангалт, эмнэлзүйн баг**

Ахлагч: Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга

Гишүүд :

- ЭМГ-ын Ерөнхий нягтлан
- ЭМГ-ын Эдийн засагч
- ЭМГ-ын Эмийн чанар аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
- ЭМГ-ын Сувилахуйн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- ЭМГ-ын Эх хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Орчны эрүүл мэнд, халдварын сэргийлэлт, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар хариуцсан мэргэжилтэн
- БОЭТ-ийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга
- БОЭТ-ийн Ерөнхий нягтлан
- БОЭТ-ийн Сувилахуйн албаны дарга
- БОЭТ-ийн Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч
- БОЭТ-ийн Халдвартын тасгийн эрхлэгч
- БОЭТ-ийн Үйл оношийн тасгийн эрхлэгч
- БОЭТ-ийн Эмийн тасгийн эрхлэгч

**3. Мэдээлэл, харилцаа холбоо, сургалт, сурталчилгааны баг**

Ахлагч: ЭМГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: ЭМГ-ын Статистик мэдээллийн мэргэжилтэн

- ЭМГ-ын Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл сургалт сурталчилгаа, хариуцсан мэргэжилтэн
- ЭМГ-ын Мэдээлэл, технологийн ажилтан
- НЭМТ-ийн Халдварт бус өвчний тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн
- НЭМТ-ийн Зураглаач
- НЭМТ-ийн Сэтгэлзүйч
- БОЭТ-ийн Сургалтын асуудал хариуцсан ажилтан
- БОЭТ-ийн Мэдээлэл, технологийн ажилтан

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны _01_ сарын _31_ -ны _А/06_
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

# ТӨЛӨВЛӨЛТ, ТАНДАЛТ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ БАГИЙН ТОХИОЛДОЛ ДЭГДЭЛТИЙН ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

| Тохиолдол, дэгдэлтийн өмнөх үед | Тохиолдол дэгдэлтийн үед | Тохиолдол дэгдэлтийн дараа |
|---|---|---|
| 1. Иргэдэд халдвараас сэргийлэх талаар МСС-г эрчимжүүлэх<br>• Видео шторк<br>• Инфографик<br>• Зөвлөмж<br>• Гарын авлага<br>• Зурагт хуудас<br>2. Хөл хорио, хязгаарлалт тогтоосон шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангуулах, хянах<br>3. Эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх<br>4. Эрүүл мэндийн салбар нэгжүүдийг мэргэжил, арга зүйгээр хангах<br>5. Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг сургалтад хамруулах<br>6. Болзошгүй дэгдэлтийн үеийн хангалтын нөөц бүрдүүлэх, зөвлөмж өгөх, нөөцөд үнэлгээ хийх<br>7. Халдварын үед шаардлагатай эм хэрэгслийн нөөцийн мэдээллийг авч, нэгтгэн, бүртгэх<br>8. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний ерөнхий удирдлагыг хангаж, багуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах<br>9. Шуурхай хариу арга хэмжээний 2-3 багийг бэлтгэж, сургах дадлагажуулах<br>10. Томуугийн өвчлөлийн мэдээнд дүгнэлт хийж, хариу арга хэмжээг төлөвлөх<br>11. Нөхцөл байдлын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, нотолгоонд суурилсан үнэн зөв мэдээллээр холбогдох байгууллага, албан тушаалтыг хангах<br>12. Шаардлагатай үед нэмэлтээр дайчлан ажиллуулах эмч, эмнэлгийн мэргэжилтний судалгааг гаргах, сургалтад хамруулах<br>13. Анагаахын чиглэлээр суралцаж буй резидент эмч, төгсөх ангийн оюутны судалгааг гарган, дайчлан | • Эрүүл мэндийн байгууллагуудаас Шадар сайдын 2017 оны 08 дугаар тушаал, ЭМС-ын 2017 оны А/527, 2020 оны 19 дүгээр албан даалгаврыг баримтлан холбогдох мэдээллийг авч, нэгтгэн ЭМЯ, ЗӨСҮТ, ХӨСҮТ-ийн Шуурхай удирдагын нэгжид мэдээлэх<br>• Голомтод хариу арга хэмжээг хэрэгжүүлэх шуурхай багийг томилгоожуулан ажиллуулах<br>• Халдварт өвчний дэгдэлт мөн эсэхийг баталгаажуулах<br>• Тохиолдлын тодорхойлолт боловсруулах (Сэжигтэй болон батлагдсан)<br>• Тохиолдлын тодорхойлолтын дагуу тохиолдлоо эрж хайх олох<br>• Өвчлөлийн байдалд дүн шинжилгээ хийж, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах<br>• Халдварын эх уурхай, дамжих замыг таслан зогсоох арга хэмжээ хамгаалах хэрэгслийн нөөц, хангалт, зөв хэрэглээ, устгал, халдваргүйтгэлд хяналт тавих<br>• Голомтын цар хүрээг цомхотгох<br>• Халдварт өвчний дэгдэлтэд нөлөөлж болзошгүй эрсдэлт хүчин зүйлийн талаар таамаглал дэвшүүлэх, эрсдлийн үнэлгээ хийх<br>• Хорио цээрийн дэглэмийг чанд баримтлах<br>• Голомтын халдваргүйтгэлийг зохион байгуулах<br>• Нөхцөл байдлын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, нотолгоонд суурилсан үнэн зөв мэдээллээр холбогдох байгууллага, албан тушаалтыг хангах<br>• ЭМБ-уудыг мэргэжил арга зүйгээр хангах | Тохиолдол дэгдэлтийн дараах үйл ажиллагааны сургамж дүгнэлтийг боловсруулан хэлэлцэх<br>• Эрсдсэн, өртсөн, хавьтсан хүн амын хяналт шинжилгээ, бүртгэл<br>• Эцсийн халдваргүйтгэл, ариутгал цэвэрлэгээ хийх<br>• Тохиолдлын сургамж дүгнэлтийн талаар мэдээллийн хэрэгслээр мэдээлэх<br><br>Нөөцийн төлөвлөлт, хангалт, хадгалалтанд байнгын хяналт тавих<br><br>Хүний нөөц, урвалж оношлуур, эм тариа, хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийн байдалд тодотгол хийх, эдийн засгийн тооцоолол гаргах<br><br>Халдвараас сэргийлэх талаар мэдээлэл сургалт сурталчилгааг хийх |

| | | |
|---|---|---|
| ажиллуулах төлөвлөгөө гаргах<br>14. Эрсдлийн урьдчилсан үнэлгээ хийх | • Шинэ короно вирусt /2019-n cov/ халдварын болон сэжигтэй тохиолдлыг мэдээллийг ЭМГ-ын хариуцлагатай жижүүр хүлээн авч ЭМГ-ын даргад мэдээлэн, ЭМГ-ын даргын А/03 дугаар тушаалаар батлагдсан эмнэлзүйн зөвлөн туслах багийг яаралтай хуралдуулан, шийдвэр гаргуулж холбогдох хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.<br>Үүнд:<br>• Шинэ короно вирусt /2019-n cov/ халдварын болон сэжигтэй тохиолдлыг анх оношилсон эмч, эрүүл мэндийн байгууллага халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан ажиллаж, өвчтнийг яаралтай тусгаарлан, тархвар судлалын асуумжийг бүртгэж ЭМГ-ын хариуцлагатай жижүүрт утсаар мэдээлж шийдвэр гаргагчдыг үнэн бодит мэдээллээр ханган ажиллана.<br>• ЭМГ-ын даргын А/03 тоот тушаалаар батлагдсан Мэргэжлийн баг шуурхай хуралдаж хариу арга хэмжээг хэрэгжүүлэн тухайн эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил аргазүйгээр хангаж ажиллах ба сэжигтэй тохиолдол болон халдвартай өвчтөнд анхны тусламж үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагын эмч, ажиллагсдын халдварын сэргийлэлтийн дэглэмд онцгой зөвлөмж хүргүүлнэ.<br>• Өвчтнийг БОЭТ-ийн Халдвартын тасаг руу зөөвөрлөх шаардлагатай тохиолдолд түргэн тусламжийн төвийн жижүүр эмч, тархвар судлаач, жолоочийн бүрэлдэхүүнтэй баг очиж тархвар судалгааг явуулж, хариу арга хэмжээг авч, халдвартын тасагт хүргэн тусгаарлаж, БОЭТ-ийн эмчилгээ эрхэлсэн орлогч захиралд мэдээлэн, лаборант томилуулан холбогдох шинжилгээг авахуулан сорьцыг лабораторит хүргүүлж шинжлүүлнэ. Шаардлагатай тохиолдолд ХӨСҮТ-д сорьцыг ЭМС-ын 2016 оны А/93 тушаалын дагуу хадгалж, тээвэрлэн хүргэнэ<br>• Шинэ короно вирусt /2019-n cov/ халдварын болон сэжигтэй тохиолдолтой хавьтал болсон эрүүл мэндийн байгууллагын ажилтан бүр ЭМС-ын 536, 537 тоот тушаалыг чанд | |

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 01 сарын 31 -ны А/06
дугаар тушаалын гуравдугаар хавсралт

**Бэлэн байдал, нөөц хангалт, эмнэлзүйн багийн ажиллах журам**

2.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээ, тусгаарлах, эрчимт эмчилгээний тасгийн эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах, шаардлагатай нөөц бүрдүүлэх
2.2. Шинэ коронавирусын шалтгаант хүнд хэлбэрийн уушгины үрэвслийн эмнэлзүйг зөвлөмж, оношилгоо эмчилгээний чиглэлээр эмч мэргэжилтнүүдийг сургах
2.3. ЭМС-ын 2020 оны А/32 тушаалаар батлагдсан эмнэлзүйн зөвлөх багаас мэргэжлийн зөвлөгөө авч, шаардлагатай тохиолдолд дэмжлэг авах
2.4. Эрүүл мэндийн байгууллагуудын хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөцийн судалгааг гаргах, бэлэн байдлыг хангах, нөөц бүрдүүлэх
2.5. Тусламж үйлчилгээний урсгал хөдөлгөөнийг зохицуулах
2.6. Эмнэлгийн халдвараас сэргийлэх дэглэмийн мөрдөлтөнд хяналт тавих
2.7. Томуу, томуу төст өвчний эмнэлзүйн удирдамж, амьсгалын замын цочмог халдвартай жирэмсэн эмэгтэйчүүдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах
2.8. Амьсгал удирдах, ТТӨ-ний эмнэлзүйн удирдамжаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг давтан сургах

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 01 сарын 31 -ны А/06
дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

**Мэдээлэл, харилцаа холбоо, сургалт сурталчилгааны багийн ажиллах журам**

- Нөхцөл байдлын талаарх мэдээллийг олон нийтэд тухай бүрт шуурхай үнэн зөв мэдээлэх
- Цаг үеийн асуудлаар шууд ярилцлага зохион байгуулах
- Үүсч болох эрсдэлээс сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран зохион байгуулах
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээний мэдээлэлд тандалт хийж, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулах
- Зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн мэдээлэл боловсруулж, түгээх, иргэдийн санаа бодлыг тандах зэргээр эргэх холбоо тогтоож, хамтран ажиллана.
- Иргэдийн дунд тархаж буй мэдээлэл, ам дамжсан цуу яриаг тандаж, залруулан, нотолгоонд суурилсан, үнэн зөв мэдээллийг түгээнэ.
- Хэвлэл мэдээлэлд ярилцлага өгөх албан тушаалтныг томилно.
- Салбар хоорондын мэдээлэл дамжуулах, солилцох үйл ажиллагааг гүйцэтгэнэ.
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байгаа мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ, цахим тандалт хийн, эерэг сөрөг мэдээлэлд тохирсон хариу арга хэмжээг шуурхай авна.
- Дээд шатны болон олон улсын байгууллагуудтай шуурхай харилцаанд орж мэдээлэл солилцон үүрэг чиглэл авах.
- “Аюул, айдасын тухай сэтгэл зүйд суурилсан тайлбар зөвөлгөөг өгч хамтдаа даван туулах боломж бүрийг ашиглах” зарчмыг баримтална

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 01 сарын 31 -ны А/06
дугаар тушаалын тавдугаар хавсралт

# ҮЙЛ ЯВДЛЫГ БҮРТГЭЖ МЭДЭЭЛЭХ ХҮСНЭГТ

| | |
|---|---|
| **Үйл явдлын төрөл** | ☐ Хүний халдварт өвчин<br>☐ Мал, амьтны халдварт өвчин, гэнэтийн хорогдол<br>☐ Зоонозын шалтгаант халдварт өвчин<br>☐ Химийн осол,хордлого<br>☐ Хоолны хордлого, хордлогот халдвар<br>☐ Байгалийн гамшиг<br>☐ Химийн бодисын алдагдал<br>☐ Цацрагийн хордлого<br>☐ Шалтгаан нь тодорхойгүй өвчлөл, нас баралт<br>☐ Террорист халдлага<br>☐ Олныг хамарсан эмх замбараагүй байдал, осол гэмтэл<br>☐ Орчны бохирдол<br>☐ Бусад (бичих.................................) |
| **Үйл явдал мэдээлэгдсэн огноо** | _ _ он _ сар _ өдөр _ цаг _ мин |
| **Эх сурвалж** | ☐ Байгууллага<br>☐ Иргэн<br>☐ Интернет мэдээлэл<br>☐ Телевиз<br>☐ Радио<br>☐ Сонин хэвлэл<br>☐ Эмч, мэргэжилтэн<br>☐ Лаборатори<br>☐ Бусад |
| **Үйл явдлыг мэдээлсэн** | Байгууллага, мэргэжилтний нэр, утас...................................... |
| **Үйл явдал хаана болсон** | ..................... |

| | |
|---|---|
| **Үйл явдал эхэлсэн огноо** | **_ _ он _ сар _ өдөр _ цаг _ мин** |
| **Өртсөн:**<br>☐ Хүний тоо _ _<br>☐ Малын тоо _ _ _<br>☐ Амьтны тоо _ _ _<br>☐ Орчин (газар нутаг)Талбайн хэмжээ_ _ _ _<br>☐ Объект | |
| **Нас барсан:**<br>☐ Хүний тоо _ _ _ _<br>Хорогдсон:<br>☐ Малын тоо _ _ _ _<br>☐ Амьтны тоо_ _ _ _<br>Эвдэрсэн, сүйрсэн:<br>☐ Объектын тоо _ _ _ _ | |
| **Лабораторийн шинжилгээнд дээж/сорьц авсан эсэх:** | ☐ Тийм ☐ Үгүй |
| **Дээж/сорьцын төрөл:** | |
| **Лабораторийн шинжилгээний дүн:** | |
| **Нэмэлт мэдээлэл:** | |

| | |
|---|---|
| **Мэдээлсэн:** | Байгууллага_______________<br>Албан тушаал ___________<br>Нэр ________________<br>Гарын үсэг ______________ |

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 01 сарын 31 -ны А/06
дугаар тушаалын зургаадугаар хавсралт

# Хариу арга хэмжээг зохион байгуулах хугацаа, хэрэгжүүлэх арга хэмжээ

| Хариу арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа /цагаар/ | ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ТҮВШИНД |
|---|---|
| Эхний 1 цагийн дотор | • ТУТ-ны багийг тухайн эрсдлийн шинж чанараас хамааран зарлан мэдээлж, дуудах, цуглуулах |
| Эхний 2 цагийн дотор | • Мэдээллийг нягтлан шалгаж, баталгаажуулах<br>• Хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх |
| Эхний 6 цагийн дотор | • Эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээний дагуу эрсдлийн түвшинг үнэлнэ.<br>• Эрсдэлийн үнэлгээг шийдвэр гаргагч нарт танилцуулна.<br>• Иргэдэд үнэн бодит мэдээллийн хүргэнэ.<br>• Хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх |
| 24 цагийн дотор | • Холбогдох байгууллагуудтай холбоо тогтоох, мэдээлэл солилцох<br>• Бусад мэргэжлийн байгууллагуудтай холбогдож ажиллах, хариу арга хэмжээний төлөвлөгөө гаргах<br>• Нөхцөл байдлыг хянах<br>• Хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх |
| 48 цагийн дотор | • Эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээний дагуу эрсдлийг дахин үнэлнэ<br>• Хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх<br>• Иргэдэд цаг үеийн мэдээллийг хүргэнэ. |
| 72 цагийн дотор | • Хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж, нөхцөл байдлаа тодорхойлох<br>• Нөхцөл байдал хүндэрсэн, орон нутгийн хариу арга хэмжээнэс давсан тохиолдолд дээд шатны болон олон улсын байгууллагад хандах, хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлэх. |
| 7-14 хоногийн дотор | • Тохиолдолын дараах сэргээх асуудлуудыг төлөвлөх хэрэгжүүлэх.<br>• Хариу арга хэмжээг хянаж, сургамж дүгнэлт боловсруулах<br>• Нөхцөл байдлын тайланг бэлтгэх |
| Идэвхжлийн зэргийг бууруулсан үед | • Үнэлгээ хийх<br>• Сургамж дүгнэлтийг хэлэлцэх<br>• Тайлагнаж, зөвлөмж гаргах |